

БАТЛАВ:



СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН ДЭД
ЗАХИРАЛ Д-р Б.ОЧИРХУЯГ

МУИС-ИЙН ОЮУТНЫ БАЙГУУЛЛАГА, КЛУБУУДЫН ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

Зорилго: МУИС-ийн оюутны байгууллага, клубуудын үйл ажиллагааг нийт оюутнуудад сурталчилах, гишүүнчлэлд бүртгэх тэдний үйл ажиллагааг өргөжүүлэх сайжруулахад оршино.

Зохион байгуулагч: МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтэс

Зохион байгуулах газар: Номын сангийн 1, 2-р давхарт болно.

Хэзээ: 2018 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр 11:00-17:00 цагт

Хамрах хүрээ: МУИС-ийн оюутны байгууллага, тогтмол идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй шилдэг клубууд оролцохоос гадна сургуулийнхаа шилдэг клубт элсэн ажиллах сонирхолтой, зорилготой нийт оюутнууд хамрагдах боломжтой.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Оюутны байгууллага, клубуудын бодлого чиглэл, үйл ажиллагаа, үйлчилгээг сурталчилах
- Өдөрлөгийн хүрээнд бусад оюутнуудын санал санаачилга, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаанд тусгах /саналын хуудас, саналын хайрцаг, тухайн хамт олоны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх зэрэгээр/
- Оюутны байгууллага, клубын үйл ажиллагаанд олон нийтийг татан нийт оюутныг татан оролцуулах, сэдэлжүүлэх
- Өдөрлөгийн хүрээнд гаргасан саналыг МУИС-ийн захиргаа, Оюутны алба болон бодлого боловсруулах байгууллагад танилцуулах, шийдвэрт тусгуулах ажлыг зохион байгуулах

Зохион байгуулах хэлбэр: Нээлттэй өдөрлөг, нэг цэгийн үйлчилгээ, танилцуулах хэлбэрээр зохион байгуулах ба бүх оролцогчид тайз болон дэлгэцэнд өөрсдийн үйл ажиллагааны танилцуулга бусад танилцуулгаа нээлттэй нийтэд танилцуулах журмаар зохион байгуулагдана.

Өдөрлөгийн гарах үр дүн: Оюутны байгууллага, клубууд өөрсдийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, шинэ гишүүнчлэл авах, үйл ажиллагааны тайлангаа нээлттэй танилцуулах, бусад оюутнуудын санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх болно.

Өдөрлөгийн хөтөлбөр:

11:00-12:00	Нээлтийн үйл ажиллагаа эхлэх
12:05-12:15	Нээлтийн үг; Сургалт, оюутан хариуцсан дэд захирал Б.Очирхуяг
12:15-12:20	Мэндчилгээ; МУИС-ийн Оюутны холбооны тэргүүн Г.Мандах
12:20-12:25	Урлагийн үзүүлбэр /МУИС-ийн урлагийн чиглэлийн клубууд/
12:25-12:30	Оюутны санаачлагын төсөл "NUM НАСКАТОН" танилцуулга
12:30-12:35	Клубуудын танилцуулга /идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй клубууд/
12:35-12:40	Шинэ клубуудыг танилцуулах арга хэмжээ
12:40-12:45	Клубуудын танилцуулга /идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй клубууд/
12:45-12:50	Болзол хангасан клубуудэд МУИС-ийн клубын батламж гардуулах ОТХ-ийн дарга М.Эрдэнэчимэг
12:50-12:55	Клубуудын танилцуулга /идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй клубууд/
13:00-16:50	Өдөрлөгийн арга хэмжээ нээлттэй үргэлжлэх
16:50-16:55	Хаалтын үйл ажиллагаа
16:55-17:00	Дурсгалын зураг татуулах /бүх зочид, оролцогч клубын төлөөлөл/